# ALL NATIONS GOSPEL PUBLISHERS



Copyright ANGP

www.angp-hb.co.za

info@angp.co.za

# ХҮМҮҮНИЙ БА СҮНСЛЭГ ЗҮРХНИЙ ТОЛЬ

(Ёгтлон дүрслэсэн арван зураг)

Энэхүү товхимол нь хамгийн анх 1732 онд Францад хэвлэгдэж, хожим нь номлогч Гшвенд Африкт илгээлтээр ажиллаж байхдаа дахин шинэчлэн бичжээ. Тэр цагаас хойш 250 гаруй хэлээр орчуулагдаж, одоогоор дэлхийн 127 улсад хэдийнээ хэвлэгдээд байна. Эл гайхамшигт номын ачаар манай гаригийн янз бүрийн отог омог, овог аймаг, үндэстэн ястны сая сая хүмүүс Бурханд зүрх сэтгэлээ өгөөд зогсохгүй, Бурханы үнэнийг дэлхийн хаа сайгүй түгээсээр явна. Есүсийг мэндлэхээс 586 жилийн өмнө тахилч Езекиелээр дамжуулан Бурхан тунхаглахдаа: **Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг оруулна. Би та нарын махан биеэс чулуун зүрхийг чинь зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө гэжээ.** ***Езекиел 36:26-28.***

Copyright ANGP

**COPYRIGHT**

**ISBN 978-1-920322-33-5**

**All Nations Gospel Publishers**

**P.O.BOX 2191, PRETORIA,0001,R.S.**

*(A Gospel Literatur Mission financed by donations)*

*(Reg. No. 1961/001798/08)*

# ХҮМҮҮНИЙ ЗҮРХ

## БУРХАНЫ СҮМ ЭСВЭЛ ЧӨТГӨРИЙН ОРОМЖ
## 1 ИОХАН 3:4-10

Энэхүү номыг уншиж байхдаа Та өөрийгөө оюун ухаандаа төсөөлөөрэй. Та Христэд итгэдэг нэгэн байсан ч, итгэдэггүй нэгэн болovч Бурхан таныг харж байгаа шиг Та өөрийгөө хараарай. Бурхан хүнтэй адил хардаггүй. Хүн гаднах төрхийг хардаг бол Эзэн зүрхийг хардаг. **1 Самуел 16:7** Бурхан, хүмүүсийн жинхэнэ төрх, мөн чанарыг нь хардаг.
Сатан худал хуурмагийн эцэг учраас харанхуй бурангуйн хаан юм. Тэр төрхөө хувирган Тэнгэр элчийн дүрээр хүмүүсийг буруу замд уруу татдаг. Одоо үед ч, өмнөх үеүдэд байсан шиг хуурамч дүр эсгэдэг Номлогчид байсаар л байна. Сатан ч өөрийгөө Тэнгэр элч болгон харуулдаг учир гайхах юу билээ. **2 Коринт 11:12,13**.
Дэлхийн эзэн Сатан хүмүүсийг харанхуйд төөрүүлдэг учир тэд Бурханы хайр хийгээд Есүс өөрсдийнх нь төлөө үхсэнийг харж чаддаггүй. **2 Коринт 4:4** Бүх Нүгэлтнүүд өөрсдийн нүгэл хилэнц дотроо л үхсэн. Тэд нар Чөтгөрийн замаар явсан юм. **Ефес 2:1-2** Нүгэлтэнүүд нүдээ нээхгүй байсаар буруу замд орж мөнхийн харанхуйд төөрдөг. “Би хэзээ ч нүгэл үйлдэж байгаагүй” гэж байгаа хүн өөрийгөө л хуурч байна. **1 Иохан 3:8**
“Хэрвээ Бурханыг хүлээн зөвшөөрч, чөтгөрийг эсэргүүцвэл тэр чамаас зугтан одно. Бурханд ойртон очигтун, тэгвэл Тэр чам руу ирнэ.” **Иаков 4:7-8**
Та энэ номыг уншиж, зургуудыг харсанаар өөрийнхөө зүрхийг гаднаас нь энгийн харж чадна. Бурханы гэрлийг зөвшөөрч түүнд өөрийн зүрхээ харуул. Нүгэлтэй гэдгээ хүлээн зөвшөөр. Бурхан хэлэхдээ “Та нар нүгэлтэй гэдгээ битгий үгүйсгэ, чи зөвхөн өөрийгөө л хуурч байна, тэгвэл чамд ямар ч үнэн байхгүй болно. Харин чи надад нүглээ наминчилбал, би чамд амалсандаа хүрч зөв замаар дагуулна. Би чамайг уучилж, нүглээс чинь ариусгана.” **1 Иохан 1:1-10.** Бурханы хүү Есүсийн цусаар бид ариусгагдсан юм.

Чи Сатан болон Бурханы алийг нь ч дага хамаагүй, чи нэг бол нүглийн боол хэвээрээ үлдэж эсвэл Бурханы зарц болно. Хэрэв нүгэл чамайг удирдаж байвал түүнийг бүү хүлээн зөвшөөр. Харин Бурханд хандан уйл басхүү гэмш. Тэр чамайг болон биднийг аврахаар ирсэн Эзэн Есүсээр дамжуулан Сатаны хар хүчнээс чамайг чөлөөлнө.. Бурхан бидний аврагч юм. Бурхан, бидний бүх нүглийн нууцыг мэддэг. Бурханы харцнаас нуугдах ямар ч боломжгүй. Бурхан чихийг бүтээсэн байж сонсохгүй гэж үү, тэр

Copyright ANGP

нүдийг бүтээсэн атлаа харахгүй гэж үү. **Дуулал 94:9**
Бурхан дэлхийг тэр чигээр нь харж чаддаг учир өөрт нь зүрхээ бүрэн зориулсан хүмүүст л хүчийг өгдөг. **Шастрын дэд 16:9**
Бурханы мэлмий хүний зам мөрийг ажиж, тэдний алхаа бүрийг хардаг. Гэм бурууг үйлдэгсэд Бурханаас өөрсдийгөө нууя гэвч, тэднийг далдлах сүүдэр ч гүн харанхүй ч байхгүй. **Иов 34:21-22**
Харин Есүсийн хувьд тэдэнд өөрийгөө даатгаагүй. Учир нь Тэр бүх хүнийг мэдэж байв. **Иохан 2:24** Алдаа мадаг нь уучлагдаж, нүгэл хилэнц нь далдлагдсан нэгэн юутай ерөөлтэй, тэрээр Бурханы өмнө гэмтэн гэж тооцогдохгүй бөгөөд, сүнсэндээ заль мэхгүй нэгэн юутай ерөөлтэй вэ? **Дуулал 32:1-2**

# ЗУРГИЙН ТАЙЛБАР

## НЭГ ДЭХЬ ЗУРАГ

Энэ зурагнаас Та дэлхийлэг нүгэлтэй хүний зүрхийг харж байна. Ариун Библид бичсэнээр: Чөтгөрөөр удирдуулсан хилэнц ихтэй хүнийг нүгэлтэн хэмээдэг. Бурханд таны зүрх энэ зураг шиг л илхэн харагдаж байгаа.

Хэн золгүй вэ?
Хэн зовиурлана вэ?
Хэн хэрүүл хийнэ вэ?
Хэн гомдоно вэ?
Хэн шалтгаангүйгээр шарх сорви олов?
Хэн улаан нүдлэв?

Тэд бол дарстай зууралдагсад ба холимог дарсыг амтлахаар одогсод юм. Улаан байхад нь , аяган дотор хөөсрөн шуугиж байхад нь, доошоо зөөлөн урсаж байхад нь, дарс руу бүү хар. Эцэст нь тэр хорт могой шиг чамайг хатгана. Нүд чинь элдвийн юм үзэж, ухаан санаа чинь самуурна. **Сургаалт үгс 23:29-33**. Эхний зурагт байгаа хүний зүрхэнд төрөл бүрийн догшин, идэмхий, заваан, залхуу араатан амьтад үүрлэжээ. Зүрх бол нүгэл хилэнцийн сав. Бурхан өөрийн илч Иеремиагаар дамжуулан хэлэхдээ:
Зүрх бол бүх зүйлээс илүү хуурамч бөгөөд эдгэршгүй өвчтэй. Үүнийг хэн ойлгож чадах билээ **Иеремиа 17:9** гэжээ.
Есүс номлохдоо: Хүмүүсийн зүрхнээс хорон муу бодол, садар самуун, хулгай зэлгий, аллага, завхайрал, шунахайрал, балмад явдал, заль мэх, тачаангуй байдал, атаархал, гүтгэлэг, бардам зан, мунхаглал л гардаг. Энэ бүх хорон зүйлс нь зүрхэн дотроос нь гарч хүнийг бузарладаг **Марк 7:21-23** гэжээ.

Copyright ANGP




1. НҮГЭЛТЭЙ ХҮНИЙ ЗҮРХ

**1.Тогос** -Энэ шувууны үзэсгэлэнтэй гоёмсогийг хүмүүс гайхан шагшдаг. Харин хүний зүрхэнд болохоор энэ нь гайхуулан бардамнаж онгирон сагсуурах нүглийг илэрхийлнэ. Нэгэн цагт Бурханы хамгийн сайн Тэнгэр элч нарын нэг байсан Лусифер хэтэрхий бардамнаснаасаа болж Бурханы дайсан-чөтгөр болжээ. **Исаиа 14:9-17 Езекиел 28:12-17**

Бардамнал нь тамын ёроолоос гардаг бөгөөд бүхий л талаараа илчлэгдэж байдаг. Зарим хүмүүс өөрийн хөрөнгө чинээ, боловсрол мэдлэг, нүцгэн биений гоо сайхнаараа бусдад гайхуулан сагсуурдаг тухай **Исаиа 3:16-24** тодорхой өгүүлсэн буй. Өөр зарим хүмүүс өөрсдийн өвөг дээдэс, үндэс угсаа, соёл уламжлал, урлаг спорт гэх мэт зүйлсээрээ ихэрхэн онгирдог. Бурхан бардам хүнийг эсэргүүцэж, харин даруу нэгэнд нигүүлсэлээ өгдөг билээ. **1 Петр 5:5** Бардамнал, ихэмсэг зан, хорон муу зам ба гажсан амыг би жигшдэг. **Сургаалт үгс:8:13** Сүйрлийн өмнө бардам зан илэрдэг байхад бүдэрч унахын өмнө дээрэлхүү зан явдаг. **Сургаалт үгс 16:18**

**2. ЯМАА** -Энэ амьтан хүсэл тачаал, бузар явдал, завхайрлыг төлөөлдөг. Иймэрхүү нүгэл өнөө цагт бүр ч их дэлгэрчээ. Эцсийн өдөр хүртэл бид үнэнээ хэлэх ёстойг Есүс урьдчилан сануулсан билээ. Эс тэгвээс энэ дэлхий яг л 2000 жилийн тэртээх Содом, Гоморах хотууд шиг газраас арчигдах болно.Зөвхөн иймэрхүү нүгэлд хүлэгдэн амьдарч буй хүмүүс төдийгүй шашин, сургууль, эмнэлэгийн газрын зарим хүмүүс ч ийм хорлолд өртдөг. Өнөө цагт ичгүүр сонжуургүй ийм байдал урлаг утгазохиол, театр, кино гэх мэт төрлөөр хүний зүрхнээс гарч Бурханы нүгэл хэмээн үздэг зүйлс орчин цагийн ёс суртхуун болж байна.Олон сая залуус амьдралын зорилго, алс ирээдүйн төсөөллөө зөвхөн кино, урлаг, уран зохиолоос авсныхаа хариуд нь харамсал, зовинол ичгэвтэр байдалд л орцгоодог. Эрээ цээр, ичгүүр сонжуураа алдсан нэр цуутай жүжигчид залуу үеийнхний бахархал дууриалал, бүжиг цэнгээний газрууд бузар булай, садар самуун, шалиг завхайн үүр болов. Бурханы ариун баатар Иосеф болон бусад нь ч үргэлж сайн үлгэр дууриал үзүүлж чадаагүй билээ. Гэр бүл үймүүлэгчдийг гэсгээхийг хүсдэг буруу номтон Зулу адил бид их шүүлтийн өдөр шүүгдэнэ. Бурхан бидэнд бузар булайгаар бүү оролд харин зугт хэмээн сургасан. “Бусад нүгэл хүний биед нөлөө үзүүлдэггүй, харин садар явдал түүний биед сөрөг нөлөө үзүүлдэг. Та нарын бие ариун сүнсний орон болж Бурханд харъяалагддаг гэдгийг мэддэггүй юм уу?” **1 Коринт 6:18,19**. Хэн нэгэн Бурханы сүмийг нураавал Тэр түүнийг устгана Учир нь Бурханы сүм ариун бөгөөд та нар өөрсдөө тэрхүү сүм юм. **1 Коринт 3:17**

**3. ГАХАЙ** -Энэ бол ховдог шунахай, сувдаг сэтгэлийн нүгэл юм. Гахай үргэлж өлсгөлөн явж, замдаа тааралдсан цэвэр бохир бүхнийг

Copyright ANCP

иддэг. Ийм нүгэлт зүрх бүх бузар булай, уран зураг утга зохиолыг залгина. Бие нь Бурханы орших сүм байтал нүгэлт зүрх нь бохир хүнс, тамхи, хар тамхи, эм зэрэг зүйлсээр тэжээгдэж байдаг. Хар тамхи татаж дадсан хэн ч тэрхүү ангалаасаа гарч чадалгүй ёроолд нь хаягдана. Зөвхөн Бурханы хүч л тамхины мансуурал, чөтгөрийн боолчлолоос чөлөөлж чадна. Сүсэг бишрэлтэй хүмүүс сүмд тамхи татаж зүрхэлдэггүй. Энэ бодол нь Бурханыг доромжилж буй хэрэг юм. "Та нар мэдэж байгаа, та нар Бурханы сүм бөгөөд Түүний ариун сүнс та нарын дотор буй! Хэрэв хэн нэгэн Бурханы сүмийг сөнөөвөл, Бурхан түүнийг ч мөн сөнөөнө"хэмээн номлогч Паул хэлсэн.
**1 Коринт 3:16,17, 6:18,19** Шуналтай хүн бол Бурханы өмнө үзэн ядагдах үнэ цэнэгүй нэгэн аж. Бид амьдрахын тулд иддэг болохоос идэхийн тулд амьдардаггүй. Бид өлсвөл хоол идэж цаддаг, харин шунал үргэлж л өг,өг хэмээн нэхсээр байдаг. Шунал хэзээ ч цадаж ханаж үзээгүй. Хуучин гэрээнд бичсэнээр шуналтан болон архичид чулуугаар шидүүлж үхнэ хэмээсэн. **Дэд хууль 21:18-21** Архичид, шунахай хүмүүс хэзээдээ үгүйрнэ. Хэрэв та зөвхөн идэж унтахыг чухалчилдаг бол удахгүй ноорхой хувцас өмсөнө. **Сургаалт үгс 23:21** Санагтун, баян хүн өөрийн ховдог шунахай зангийнхаа боол болж, эцэстээ үхээд өөрийгөө тамын гүн ёроолд чулууддаг. Ховдог шунахай зангүй хүн мөнхийн хаант улсад очих тухай Бурханы сургаалд буй. Ухаан сэхээгүй архидалт чамайг тэнэг мунхаг, харалган бодлогогүй болгоно. Уух шиг тэнэглэл үгүй. **Сургаалт үгс 20:1** Хатуу үндааг хийж, зарсан хэн ч Бурханы өмнө нүгэлтэн юм. Бурхан хэлэхдээ "Дарс уухдаа зоригтой, хатуу архи найруулахдаа баатарлаг байгчид гаслантайяа" **Исаиа 5:22** хэмээжээ. Нүцгэн биеийг нь харахын тулд хор найруулан хөршөө согтоогч хүн хөөрхийлөлтэй еэ **Хабаккук 2:15** Эсвэл та нар зөвт бус хүмүүс Бурханы хаанчлалыг өвлөхгүй гэдгийг мэддэггүй юм уу? Бүү мэхлэгдэгтүн. Садар самуун явдалтнууд, шүтээн шүтэгчид, завхайрагчид, янхан эр, ижил хүйстэнтэйгээ нөхцөгчид, хулгайч нар, шуналтангууд, архичид, хараалчид, дээрэмчидийн аль нь ч Бурханы хаанчлалыг өвлөхгүй. **1Коринт 6:9,10** Үнэндээ, хүний нүгэл гэдэг хэмжээлшгүй. Бохир бузар, завхай зайдан, ёс журамгүй явдал, мухар сүсэг, чөтгөр болон бусад бурхадыг шүтэх гэх мэт болой. Хүмүүс хоорондоо дайсагналцан дайтаж, атаархан хорсож, уурлан хилэгнэх болжээ. Хүмүүс тус тусдаа талцаж, бүлэглэл болж уудаг, садарладаг, атаархдаг, мөн үүнтэй адил бузар зүйлсээр хуваагдах аж. Эдгээрийг хийгчид Бурханы ээзнт гүрэнд тохирохгүй. **Галат 5:19-21** "Дарсанд бүү согт, чамайг сүйрлээс өөр юунд ч хүргэхгүй. Зөвхөн ариун сүнсээр дүүрэн бай." **Ефес 5:18** Есүс материаллаг зүйлд дурлагчдад хандаж "Үргэлж цангадаг бол над дээр ир тэгээд цангаагаа тайл". **Иохан 7:37,38** хэмээн сургасан

Copyright ANCP

билээ. Цангасан хүн бүр ус руу ирэгтүн. Мөнгөгүй хүн бүр ирж хүссэнээрээ үнэгүйгээр дарс, сүү худалдан авагтун. **Исаиа 55:1** Миний өгөх уснаас ууж байгаа хэн ч хэзээ ч цангахгүй. Харин миний өгөх ус тухайн хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно оо. **Иохан 4:14**

**4. ЯСТ МЭЛХИЙ.** Энэ бол залхуурал, хойрго алмайд захирагдах чөтгөрийн ёрлол юм. Бослого нь чөтгөрийн хорлолтой ижил. **1 Самуель 15:23** Ажлаасаа хойргошин залхуурах нь зөвхөн өөрийгөө хорлож байгаа хэрэг юм. Тэр үнэндээ ажиллахаас дургүй нь хүрдэг. **Сургаалт үгс 21:25,26** Иошуа Израйлчуудад хандан хэлэхдээ:"Энд юу ч хийлгүй битгий зогс, хурдан очоод хүртэцгээ" гэж **Шүүгчид 18:9** бичсэнийг сана. Хүн өөрөө маш залхуу бөгөөд Бурханы өгч байгаа зүйлд хүрэхэд дэндүү удаан байдаг. Есүс хэлэхдээ: "Нарийн хаалгаар орохыг чадлаараа хичээ" **Лук 13:24** гэжээ. Хайсан нь олно. **Матай 7:8** Тэнгэрийн хаанчлал хүчинд автаж, хүчирхийлэгчид түүнийг хүчээр авахад зэхэж байна. **Матай 11:12** Залхуурал нь аврал, ариун сүнсийг бидний зүрхнээс зайлуулж мөнхийн үхэлд хүргээд зогсохгүй залбирал, бурханлаг байдал, бурханы ариун бүхнээс холдуулж биднийг сүйрэлд дагуулдаг. Хэрэв Бурхан чамтай ярьвал, түүнд зүрх сэтгэлээ даатга. Эс тэгвэл маргааш эсвэл хэзээ нэгэн цагт чөтгөрт зүрхээ эзлүүлж, Христгүй, түүний авралгүйгээр үхэх өдөр ирнэ. Бурхан хэлэхдээ: "Хэрэв Бурханы дуу хоолойг өнөөдөр сонсвол, бүү зөрүүдлэ, өвөг эцэгтэйгээ адил Бурханд бүү зөрүүдлэгтүн" **Еврей 3:7-8** Хичнээн олон хүн хэзээ ч ирэхгүй, сүнсгүй, авралгүй өдрийн төлөө үхсэн бол? Ийм нигүүсэлгүй өдөр таных биш шүү. Яст мэлхийн хуягийг чөтгөр туршилт дадлага хийхдээ ашигладаг. Чөтгөрийн дадлага, нүгэл, илбэ, мэргэ зэрэг нь Бурханы зүйлсээс тэс өөр юм. Бид онцгой тохиолдолд өвдөж зовсон үедээ л Бурханд ханддаг. Харин Тэр бидэнд туслахаар ямар ч үед бэлэн байдаг. Тэр сохор азанд итгэдэггүй. Бурхан хүнийг зөв замд нь оруулдаг юм. **Дуулал 37:23** Хэн нэгэн чинь өвчтэй байвал сүмд очиж түүний төлөө залбиран эзний нэрээр түүнийг тосоор тослогтун! Тэр залбирагч чамайг өвчнөөс чинь эдгээнэ. Бурхан түүнийг эрүүлжүүлж, нүглийг нь өршөөнө. Тэгээд өөрийн нүглээ өөр бусад залбирагч нарт наминчилж чи бүрэн эдгэрнэ. **Иоков 5:14-16**
Хүүхдээрээ тахил бүү өргө, мөн хүмүүсийг мэргэ төлөг, үхэгсдээс зөвлөгөө авахыг бүү хүлээн зөвшөөр. Чиний эзэн бурхан мухар сүсэгтэй хүмүүст дургүй. **Дэд хууль 18:10-12** Гадна талд нь ноход мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид, болоод худлыг хайрладаг, үйлддэг бүхэн байна. **Илчлэлт 22:15** Бөө болон сүнс дуудагчид уруу бүү эргэгтүн. Тэднийг битгий эрж хай. Тэгвэл та нар бузартана. Би бол Эзэн, та нарын Бурхан. **Левит 19:31** Тэд та нарт "Шивнэн чалчдаг сүнс дуудагчид болон

Copyright ANGP

шидтэнүүдтэй зөвлөлд" гэж хэлэх үед ард түмэн өөрсдийнхөө бурханаас асуухгүй гэж үү? Амьд хүмүүсийн төлөө үхэгсдээс асуух гэж үү? Хууль хийгээд гэрчлэлд анхааргтун. Хэрэв тэд энэ үгийн дагуу ярьдаггүй бол тэдэнд гэгээ байхгүй болжээ. **Исаиа 8:19,20** Та энэ номыг уншиж байхад, Бурхан тантай ярьж, таныг нүглээ орхин өөр дээрээ ир хэмээн дуудах болно. Харин нүгэлт яст мэлхий, таны зүрхэнд байгаа учир таныг энэ номноос залхааж айдаст автуулна. "Миний гэр бүл, найз нөхөд, мөн бусад хүмүүс намайг жинхэнэ Итгэгч болвол яах бол? Би бүжиг наадам, цэнгээнт үдэшлэгт очихгүй удвал юу болох вэ? Христийн баян, гайхамшигтай, аз жаргалтай, алдартай суутай, ивээл хайраар дүүрэн мөнхийн амьдарлыг харахгүй, Есүсийг зүрхэндээ оруулахгүй бол, айдас нүглээр дүүрэн Сатаны боол л болно. Ингэснээр тэр үхлийн хүч буюу чөтгөрийг үхлээрээ устгаж, бүх насаараа үхлийн айдсаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм." **Еврей 2:14,15** Залхуурлын нүгэл чамайг удирдаж чамайг яст мэлхийн хуяг мэт хатуу сэтгэлтэй болгоно.

**5. ИРВЭС** -Энэ бол маш зэрлэг балмад араатан. Өс хонзон, уур бухимдалаар дүүрэн бөгөөд ихэвчлэн аллага үйлдэхэд бэлэн явдаг. Та хичнээн хичээгээд ч өөрийн муу бодлоо удирдаж чадахгүй аймшигтай зүйл үйлдэх болно. Үүнийгээ хүлээн зөвшөөрч Есүсээр чөлөөлөгдөх нь хамгийн зөв юм. "Бүү уурла, чамд зовлон л авчирна" **Дуулал 37:8** "Уур бол хэрцгий бөгөөд сүйрэлд хүргэнэ" **Сургаалт үгс 27:4** "Өөрийн зан аашаа удирд, эс бөгөөс тэнэгээр атаархах болно." **Номлогчийн үгс 7:9** "Уурнаасаа сал" **Колоссай 3:8** Хулчгар хүмүүс чөтгөрийн үйл, атаа хорслоосоо салахын тулд архи уудаг. Тэд ууж байхдаа дарс бол могойн хор юм гэдгийг мартдаг. **Дэд хууль 32:33** Өш хонзон бол нүглээр дүүрэн зүрхэнд, сайхан зүйл юм. Гэвч Бурхан бол бурууг гэсгээгч цорын ганц. Есүс хэлэхдээ "Хөршөө өөрийн адил хайрла" **Марк 12:31** мөн "Дайснаа хайрла" **Матай 5:44** "Бурхан: Хэрвээ та нар буруу зүйл хийсэн нэгнээ уучилвал, би ч мөн та нарыг өршөөнө хэмээн айлдсан." **Матай 6:12** Бурхан уурлаж бухимддаг сүнсийг үзэн яддаг. Аймшигтай цус урсгасан дайн хүсдэг хүн, үнэн сэтгэлээсээ энх тайвныг хүсвэл эцэст нь эзний нигүүслээр аврагдана.

Copyright ANGP

**6. МОГОЙ** -Еден цэцэрлэгт байсан Бурхан, Ева хоёрын нандин нөхөрлөлийг зальт могой башир аргаараа яаж нураасныг Хуучин гэрээнд өгүүлдэг. Адам Ева хоёр дэлхийн хуулийг захирч, Бурхантай нандин холбоотой амьдарч, өөрийнх нь газрыг эзэлсэнд Сатан атаархсан. Тиймээс Адам Ева хоёр Сатаны хорлолоор өөрсдийн сүйрлийг дуудаж, Бурхантай тогтоосон ариун нөхөрлөлөө өөрсдөө сүйтгэсэн. Атаа жөтөөгөөр дүүрэн хүний зүрх, чөтгөрийн атаархалтай адилхан бөгөөд өөрөөсөө илүү нэгний аз жаргалтай,

сайхан амьдарч байхыг хараад атаархсандаа өөрөө өөрийгөө хорлодог. Атаа хорсол нь чөтгөрөөр дамжин бусдын аз жаргалыг нураах төдийгүй аллагад хүргэж ч болно. Энэ нь ихэвчлэн гэрлэсэн хүмүүст тохиолддог. Нөхрийгөө хардахдаа уур хилэндээ шатах бөгөөд түүний өш хонзон хязгааргүй. **Сургаалт үгс 6:34** Бурханд үйлчилдэг Номлогчид, Пасторууд бусдын атаархалд илүү өртөмхий учир Бурхан тэднийг ашигладаг. Найдвар нь урам хугалдаггүй, учир нь бидэнд өгөгдсөн ариун сүнсээр дамжуулан Бурханы хайр бидэнд цутгагдсан байдаг. **Ром 5:5** Бусад тохиолдолд атаа жөтөө ямар ч хэрэггүй.

**7. МЭЛХИЙ -**Энэ амьтан ховдог шунахай сэтгэл, мөнгөнд дурладаг чөтгөрийн угшил юм.
**1 Тимот 6:10** Конгод байсан мэлхийнүүд шоргоолжийг зуу зуугаар нь хагарч үхтлээ идэж байсан. Шуналтай хүн ядуу зүдүү хүнд гараа сунгадаггүй атал, дэлхийн хамгийн баян хүн болохын тулд бүхнийг хийдэг. Есүс хэлэхдээ: “Энэ амьдралдаа баян байхыг бүү бодогтун, учир нь цагаан эрвээхий идэж, хулгайчид хулгайлах болно. Харин Диваажинд баян байгтун, учир нь цагаан эрвээхий идэж чадахгүй, хулгайчид ч хулгайлж чадахгүй. Зүрх сэтгэл чинь хаана байна тэнд баялаг чинь оршдог.” **Матай 6:19-21** Ахан гэр бүлээрээ алт мөнгөнд дурласнаасаа болж чулуугаар шидүүлж үхсэн. **Иошуа 7** Есүсийн дагалдагч байсан Иудас мөнгөнд шунаж, эзнээсээ урвасныхаа төлөө өөрийгөө дүүжилсэн. Мөнгө болон алт нь чөтгөр биш юм. Харин мөнгөнд дурлах нь хүний зүрхэнд нуугдсан чөтгөр юм. Мянга мянган хүмүүс өөрсдийн амьдралыг л тансаг болгож гэр бүлээрээ баяжихын тулд асар их мөнгийг морь, нохойн уралдааны бооцоонд тавих зэргээр хийсгэж байна. Баялаг нь анхнаасаа хулгай, аллага, амиа хорлолттой хамт ирдэг. Мөнгөнд дурлах нь араасаа олон муу зүйлсийг дагуулдаг. Алдар нэр, улс төрийн эрх мэдэл, шашины эрх мэдэл сүм Бурханы нэрээр Бурханы дагалдагч хүмүүсийг мунхруулах гэх мэт зүйлс ордог. **Марк 9:38** Есүс хэлэхдээ: “Сайн хар, өөрийгөө бүх шуналаас хамгаал, үнэнээр амьдарсан хүн баялаг бүтээж баян болдоггүй. ” **Лук 12:15** Нэгэн баян хүний эдлэн газар нь маш үржил шим сайтай байжээ. Тэр хүн “Ургацаа хадгалах байр савгүй одоо би яадаг билээ? гэж бодов. Би ерөөсөө хуучин Пингээ буулгаад илүү том пин барья. Тэндээ л хамаг ургац, хөрөнгөө хадгалъя. Тэгээд би өөртөө /Санаа сэтгэл минь, чамд хожмын олон жилийн турш хэрэглэх хөрөнгө байна. Өөрийгөө амраа, ид, уу, зугаац гэж хэлнэ дээ гэсэнд Бурхан “Тэнэг ээ, чи өнөө шөнөдөө үхнэ. Тэгвэл чиний баялгийг хэн авах вэ? гэжээ”. Тэр хүн зөвхөн өөрийнхөө төлөө баялгийг хураагч бөгөөд Бурханы өмнө ядуу болой. **Лук 12:16-21** Учир нь бүх дэлхийг авсан ч амиа алдвал ямар ашиг байх вэ? **Марк 8:36** Би та нарт хэлье. Амьдрахын тулд юу идэх вэ, биедээ юу

Copyright ANGP

өмсөх вэ гэж бүү санаа зов. Бурхан эцэг тань та нарт хаанчлалаа баяртайгаар өгнө, яагаад гэвэл та нарын баялаг хаана байна тэнд бас зүрх сэтгэл чинь байх болно. **Лук 12:22-34**

**8. САТАН** -Сатан нь худал хуурмагийн эцэг агаад хүмүүсийг нүгэлд уруу татагч, нүгэлт зүрхний удирдагч юм. Есүс хэлэхдээ "Та нар эцэг чинь болох чөтгөрөөс гаралтай, Та нар эцгийнхээ хүслийг гүйцээхийг хүсдэг. Тэр эхнээсээ л алуурчин байсан бөгөөд үнэн дотор хэзээ ч зогсдоггүй. Тэгээд ч худал хуурмаг бол чөтгөрийн өөрийнх нь үг юм. Учир нь тэр өөрөө худалч бөгөөд худал хуурмагийн эцэг нь билээ. **Иохан 8:44** Том жижиг худал гэж үгүй, худал л бол худал. Бичигдсэн, яригдсан, үйлдэгдсэн худал хуурмаг буй. Бурхан худал хэлдэггүй бөгөөд Христ ч мөн адил. **Тит 1:2** Хэрэв бид Бурхантай нөхөрлөдөг гэж хэлээд, харанхуйд алхаж байвал, бид худал хэлж, үнэнийг үйлддэггүй ажээ. **1 Иохан 1:6** Тэнгэрлэг зүйлсээс гадна, ноход, мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид болоод худлыг хайрладаг үйлддэг бүхэн байна. **Илчлэлт 22:15** Бурхан худал ярьдаг хуурамч гэрчлэгчийг үзэн яддаг. **Сургаальт үгс 6:19**

**9. ОД** -Од нь хүний дотоод сэтгэлийг илтгэнэ. Энэ нь бузар булай, муу муухай нэн ялангуяа аллага таллага зэрэг зориуд үйлдэгдэх харалган хилэнцэд баригдаж өөрийгөө шүүх ямар ч чадваргүй болсон ухамсар юм. Энэхүү чөтгөрийн ухамсар нь нэг болохоор нам гүм, нэг болохоор тарчилган зовоож байдаг. Хэрвээ тэр шүүх бол уучилж, уучлах бол шүүдэг. Тэд өөрсдийн мөс чанараа халуун төмрөөр тамгалан хоёр нүүр гарган худал ярьж, бузар мөс чанараас цэвэрлэгдхийн тулд өөрсдийн зүрхэндээ цацуулж биеэ ариун усаар угаалган үнэн зүрхээрээ ойртон очицгооё. **1 Тимот 4:1,2 Еврей 10:22**

**10. НҮД** -Бурхан бидний зүрхэнд буй бүхнийг хардаг. Бурханы мэлмийгээс юу ч нуугдах боломжгүй бөгөөд тэр бүхий л нууц, зүрхэнд буй бүхнийг харж чаддаг. Чи яаж ч хичээгээд чөтгөрийн хамгийн харанхуй шөнө, гүн ой, ёроолгүй нүхэнд нуугдсан ч Бурхан бүгдийг харж байдаг.

**11. БЯЦХАН ГАЛАН ХЭЛНҮҮД** -Зүрхийг тойрон эргэлдэж буй Бурханы хайр нь нүгэлтэй зүрхийг ч хайрладаг гэсэн утгатай. Бурхан нүглийг үзэн ядах боловч хүнд хайртай учир нүгэлтнийг ч үхээсэй гэж хүсдэггүй. Харин түүнийг нүглээс нь салгаж амьдруулахыг хүсдэг. **2 Петр 3:9** Есүс нүгэлтнийг аврахын тулд ирсэн юм. Тэнгэрийн улсад нүглээ ухаарсан нүгэлтнийг хүлээж авах агуу их баяр баясгалан буй. **Лук 15:7** Бяцхан хэлнүүд Есүсийн цусыг илтгэж Бурханы хурга, дэлхийг нүглээс нь салгасан. **Иохан 1:29**

Copyright ANGP

**12. ТЭНГЭР ЭЛЧ** -Тэнгэр элч нь Бурханы үгийг төлөөлнө. Бурхан нүглээр дүүрч, хилэнцэд хүлэгдсэн нэгэнтэй ярихыг хүсэж байна. Тэгээд тэд нүглээс ангижирч, ариуссан зүрхээрээ Бурханы өмнө очиж гэрэлт, зөв замдаа ордог.

**13. ТАГТАА** -Ариун сүнсний билэгдэл, Бурханы үнэнийг өгүүлэгч сүнс. Нүглийн болон үнэний тухай, мөн Бурханы их шүүлтийн өдрийн тухай өгүүлдэг. **Иохан 15:26** Ариун сүнс зүрхний гадна зурагдсан бөгөөд нүгэлт газар оршиж чадахгүй. Энэ зурган дээрхи зарим зүйлс таньтай адилхан. Бурханд зүрхээ нээж түүний гэрэлт үгсээр өөрийгөө гэрэлтүүлэгтүн "Есүст итгэ, тэгвэл аврагдана" **Үйлс 16:31** Бурхан таны зүрхийг эдгээнэ гэж амласан. Танд шинэ зүрх, шинэ оюун ухаан өгнө. **Езекиель 11:19**
Энэ талаар хоёр дахь зурганд тодорхой гарна.

Copyright ANGP




2. НҮГЛЭЭС АНГИЖИРСАН ЗҮРХ

## ХОЁР ДАХЬ ЗУРАГ

Энэ зураг дээр гэмшсэн зүрх, Бурханд хандаж эхэлсэн тухай харуулж байна. Тэнгэр элч сэлэм барьжээ. Энэ бол Бурханы үг юм. Амьд, идэвхитэй гэсэн хоёр иртэй хурц илд юм. Энэ нь ариун сүнс, сүнстэй уулзах хүртэл замдаа тааралдсан бүхнийг цавчиж өөртөө нэгтгэнэ. Энэ нь зүрхний хүсэл тачаал хийгээд санааг ч шүүх чадвартай. **Еврей 4:12** Бурханы үг түүнд сануулахдаа"Нүглийн төлөөс бол үхэл." **Ром 6:23** мөн "Бүгд нэг удаа үхэж, тэгээд Бурханы шүүлтэд орно. **Еврей 9:27**" Үл итгэгчид болон нүгэлтнүүдэд зориулсан там нь гал, хүхрээр дүүрсэн нуур байх болно. **Үйлс 21:8**

## НҮГЛЭЭС АНГИЖИРСАН ЗҮРХ

Тэнгэр элч нөгөө гартаа гавлын яс барьжээ. Энэ нь Нүгэлтнүүдэд, бүгд үхнэ гэдгийг сануулж буй хэрэг юм. Бидний ихэд хайрлаж, хооллож, хувцасладаг энэ бие бол хүсэл тачаалдаа эзлэгдсэн бөгөөд аажмаар үхэж хожим нь бүгд Есүсийн өмнө шүүгдэнэ. **2 Коринт 5:10** Энэ зурган дээрээс Нүгэлтэн Бурханы илгээмжийг хүлээн авч, Бурханд зүрхээ нээж буйг хараарай. Ариун сүнс нүгэлт харанхуй зүрхийг гэрэлтүүлж байна. Бурханы гэрэл орж ирэхэд харанхуй арилан замхарна. Энд басхүү нүгэлт амьтад дайжиж буйг харуулжээ. Тиймээс эрхэм уншигч та Есүсийг дагаж, ертөнцийн гэрэл болсон түүнийг зүрхэндээ оруулж, харанхуй ноёлсон чөтгөрийн хорлолыг энэ зурган дээрхитэй адилаар өөрөөсөө зайлуулагтун. Есүс хэлэхдээ "Би бол гэрэл, намайг дагасан хэн ч гэрэлт амьдралыг олж хэзээ ч харанхуйд төөрөхгүй." **Иохан 8:12** гэжээ. Та өөрийн хичээл зүтгэл, тэсвэр тэвчээрээр нүглийн гүн дарамтнаас гарч болно. Харин хамгийн амархан, хурдан нүглийн хүлээснээс гарах арга бол Есүсийг өөрийн амьдралд оруулж түүний гэрлийг дагаж харанхуйгаас гарах юм. Сар од зэрэг нь харанхуйд гэрэлтэх боловч, нар бүрэн жаргасны дараа тэрхүү бяцхан гэрлүүд харанхуйд уусан алга болдог. "Есүс бол үнэний нар юм. Тэрээр Иерусалимийн сүмд очихдоо, сүм доторхи худалдаачдад ихэд хилэгнэн, мөнгө, тагтаа тавьсан ширээг хөмрүүлж орхиод хэлсэн нь: Бурханы сүм бол залбирлын гэр гэж нэрлэгдэх болно гэж бичигдсэн байдаг. Гэтэл та нар үүнийг дээрэмчдийн үүр болгож байна." **Матай 21:13** хэмээдэг.Та нарын зүрх чинь Бурханы сүм юм. Тэр тэнд амьдарч, гайхалтай гэрэл, дүүрэн хайраар бялхам байхыг хүссэн. Есүс зөвхөн бидний гэмийг уучлахаар ирээгүй, басхүү нүглийн хүлээснээс чөлөөлөхөөр ирсэн билээ. Хэрэв Бурханы хүү чамайг чөлөөлбөл, чи жинхэнээсээ чөлөөлөгдөх болно. **Иохан 8:36**

Copyright ANGP




3.ГЭМШСЭН ЗҮРХ

# ГУРАВ ДАХЬ ЗУРАГ

Энэ зурагт нүгэлдээ үнэн сэтгэлээсээ гэмшсэн зүрхийг харуулжээ. Одоо тэр өөрийнх нь нүглээс болж Есүс хэрхэн цовдлуулсаныг ухаарч байна. Одоо тэр Бурханы үгийг сонсоод ямар их нүгэлтэй байснаа ойлгон харуусаж байна. Одоо тэр Бурхан өөрийн цорын ганц хүү Есүс Христээр дамжуулан бидэнд ямар их хайртайгаа харуулсанд уярч, өөрийнх нь нүглийн төлөөсийг Есүс цовдлогдон төлснийг ойлгожээ. Есүс бидний нүглээс болж ташуурдуулан, өргөст титэм зүүж, гар хөлөндөө хадаас шаалгуулж, загалмайд цовдлогдсон юм. Бид Бурханы үгийг ойлговол ямар гүн нүгэлд унаж түүний үгнээс хичнээн зөрсөнөө ойлгоно оо. Бид гүнээ харамсаж хүлцэнгүйгээр Бурханы өмнө очвол Есүс биднийг дэргэдээ авах болно. Бурханы хайр, амар тайван бидний зүрхэнд орсноор «Түүний Хүү бидний нүглийн төлөө цусаа урсгасан юм.» **1 Иохан 1:7** Бурхан минь миний зүрхийг ариутгаж, шинэ ариун сүнсийг надад өгөөч. **Дуулал 51:10** Бурхан хэлэхдээ «Би, даруухан, гэмшсэн сэтгэлтэй, миний үгэнд дуулгавартай байдаг хүн рүү л харна.» **Исаиа 66:2** гэв. Тэгээд Ариун сүнс Есүст итгэсэн хүнд , Есүсийн хэлсэн шиг «хүү минь, охин минь чиний бүх нүгэл өршөөгдсөн» гэж хэлэх болно. **Матай 9:2** Тэр Есүсийн цусаар будагдсан загалмайг харах тусам түүний нүгэл алга болж буйг мэдэрнэ. Есүс бидний хүртэх зовлонг өөрийн биеэр эдэлсэн. «Учир нь тэр бидний чөтгөрийн бодол санаагаар цохигдож үхсэн» мөн Бурхан түүн дээр өөрийн шийтгэлээ буулгасан юм. **Исаиа 53** Бурханы ариун сүнсний хайр бидний ариуссан зүрхийг удирддаг. Тэр Есүст итгэхдээ, Бурханы хүү Есүсийн цус өөрийг нь нүглээс ангижруулсан болохыг ойлгоно. **1 Иохан 1:7** Тэрбээр одоо Есүст итгэсэн хэн ч бай сүнсээрээ хэзээ ч үхэхгүй болохыг ойлгож байна.. Мөн мөнхийн амийг олох болно. **Иохан 3:16** «Бид Христийн үхлээр чөлөөлөгдлөө, энэ бол бидний нүгэл уучлагдсан гэсэн үг юм.» **Ефес 1:7** Хүний нүгэлт хүсэл тачаал Бурханд үйлчлэх хүслээр солигдлоо «Хэн биднийг анх хайрласан билээ» **1 Иохан 4:19** Дэлхий болон түүн дээрхи зүйлсийг хайрлахаас гадна Бурхан болон түүнтэй холбоотой зүйлсийг хайрладаг болно. Энэ зурган дээр нүглийг илэрхийлэгч амьтад зүрхний гадна, харин Сатан гэрээ орхихыг хүсэхгүй эргэж харан, орох арга байгаа эсэхийг харж буйг дүрсэлжээ. Есүс биднийг өөр лүү нь хандан үргэлж залбир тэгвэл Сатан зайлан одох болно гэсэн юм. **Иаков 4:7**

Copyright AWGP




4.ЕСҮСТЭЙ ХАМТ ҮХЭХ

# ДӨРӨВ ДЭХЬ ЗУРАГ

Энэ зурагт Христийн үхлээр агуу их амар тайван, мөнхийн амийг олсон Итгэгчийн тухай өгүүлжээ. Харин бидний эзэн Есүсийн загалмайгаар сайрхахаас өөр нь надад бүү байг. Түүгээр далимдуулан надад ертөнц би ертөнцөд цовдлогдсон юм. **Галат 6:14** Есүс загалмайд үхсэн шиг "нүглийн төлөө үхэж үнэний төлөө амьдар" **1 Петр 2:24**

Христэд итгэгч хүн дэлхийд үхнэ. Харин "Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлье." **Галат 5:16, 25** Энэхүү багана нь Есүс хэрхэн харгис хэрцгийгээр ташуурдуулж байсныг илтгэдэг. Тэр бидний төлөө гэсгээгдсэн"Бид түүний шархаар эдгэрсэн билээ" **Исаиа 53:5** Херод болон түүний цэргүүд Есүсийг ташуурдаж, алтан титэмний оронд өргөст титэм зүүж, модон таяг бариулж түүний өмнө мэхийн "Израйлчуудын хаан" хэмээн доромжилж байлаа. Түүний модон таягийг авч толгой руу нь цохиж байв. Есүсийг гутамшигтайгаар доромжилсоны эцэст хамгийн хатуугаар шийтгэлээ. **Матай 27:27-31** Дараа нь унасан хүмүүс өөрсдөө Бурханы Хүүг дахиад цовдолж, илэрхий гутамшиг болгодог тул тэдний хувьд гэмшилд дахин шинэчлэгдэх боломжгүй юм. **Еврей 6:6** Намайг, эзэн минь, эзэн минь гэсэн бүхэн тэнгэрийн хаанчлалд орохгүй, харин тэнгэрт байгаа миний эцгийн хүслийг биелүүлдэг хүн л орно. **Матай 7:21-27** Энэ зурагт уутттай мөнгө байгаа бөгөөд тэр нь Иуда Эзэн Есүсийг 30 зоосоор зарсаныг өгүүлж байна. Дөнлүү, гинж гэх мэт нь Есүсийг шөнөөр гянданд хорьсон цэргүүдийн хэрэглэж байсан зүйлс юм. Шоо нь ихэнхидээ мөрийтэй тоглоомонд хэрэглэгддэг бөгөөд цэргүүд үүнийг Есүсийн хувцасаар мөрий тавин тогложээ. "Тэд миний хувцасаар мөрий тавьж хувааж авцгаасан" **Дуулал 22:18** Тэд Есүсийн бүх зүйлсийг авсан боловч "Бид түүнийг өөрсдийн хаан болохыг хүсэхгүй байна" гэцгээж байв. Хүмүүс бид Бурханаас бороо, нарны туяа гээд бүх л зүйлсийг авсан боловч харин эзэнд үйлчлэхийг хүсдэггүй. Бурхан маш олон удаа бидний зовлон цөхрөлд тусалдаг. "Түүний хажуу уруу жадлахад, цус,ус гоожлоо" **Иохан 19:34-37** Тахиа донгодохоос өмнө чи надаас 3 удаа урвана гэснийг Петр санаад гашуунаар уйлав. **Матай 26:69-75** Чи өөрийн зүрхээ Есүст өгсөн гэдгээ хийж буй, хэлж байгаагаараа тунхаглаж чадах уу? Эсвэл чи бусад хүмүүс мэдчихнэ гэхээс айж байна уу Есүс хэлэхдээ "Намайг олны өмнө хүлээн зөвшөөрч буй хүн Эцгийн минь диваажинд ч хүлээн зөвшөөрөгдөнө, харин олны өмнө үгүйсгэж байгаа хүн Эцгийн минь диваажинд ч үгүйсгэгдэнэ." **Матай 10:32,33.**

Есүс өгүүлэхдээ "Хэн миний араас загалмайгаа үүрэн дагахгүй байна тэр миний дагалдагч болж чадахгүй" **Матай 10:38** Есүсийн хамгааллыг олсон хүн жаргалтай яа.

Copyright ANCP

**Мөнхийн хад халхавч минь болооч**
**Өөрийн дотор үүрд намайг нуугаач**
**Таны зүгээс урсах цус болоод ус**
**Гэмийн хүч болон буруутгалаас намайг цэвэрлэг**

## ТАВ ДАХЬ ЗУРАГ

Энэ зурагт ариусаж нүглээс ангижирсан хүний зүрх Бурханы хайр, нигүүлслээр дүүрэн байдаг тухай дүрсэлжээ. Ингэснээр хүний зүрх Эцэг, хүү, Ариун сүнсний сүм болж, Есүсийн амласанд жинхэнээсээ нийцэж байна. Хэн надад үнэнээсээ хайртай вэ? тэр миний үгийг дагах болно. Бурхан эцэг минь ч түүнийг хайрлана. Тэгээд би өөрийн эцэгтэй хамт түүн дээр ирж хамтдаа байх болно. **Иохан 14:23** "Бурханы хүндэтгэл, ивээл, урамшуулал Есүсээр дамжин ирнэ" **Лух 1:52** Энэ зүрх одоо жинхэнэ Бурханы сүм болж нүгэл зугтан оджээ. Сатаны нүгэлт амьтад, худал хуурмагийн эцэг биш харин Ариун сүнс мөнхүү зүрхэнд буйг харж байна. "Нүглийг үржүүлэх газар биш, харин шинэхэн жимс, ариун сүнс, хайр, эв нэгдэл нөхөрсөг, сайн сайхан Бурханы сэтгэлд нийцсэн зүйлсийг тарьж ургуулах газар болжээ." **Галат 5:22-23** Тэр одоо Есүсийг зүрхэндээ ургуулж байна. Энэ жимсний нууц нь Христтэй холбоотой бөгөөд Христийн үг түүнд хүрэх болно. **Иохан 15:1-10** Христэд итгэдэг хүмүүс өөрсдийн махан биеийн бузар хүслээ загалмайд цовдолсон ажээ. **Галат 5:24** Ариун сүнс түүний амьдралд орж тэр махан биеийн хүслээсээ татгалзана. **Галат 5:16** Тэр өөрийн харж, сонсож, мэдэрч буй зүйлтэйгээ удаан амьдрахгүй харин итгэл найдвартайгаа хамт амьдарч байна "Бид өөрсдийн итгэл найдварыг дэлхий дээр олов" **1 Иохан 5:4** Тэр одоо Бурханы дэргэд итгэл найдвар болж Бурханы мөнхийн хайртай хамт амьдарна. Аз жаргал зүрхийг ариусгаж, Бурханыг харах болно **Матай 5:8** Өөрийн бүх дайснаа ялж, маш баян байсан хаан Давид "Надад шинэ зүрх, басхүү Ариун сүнсийг өгөөч бурхан минь хэмээн залбирч байсан тухай" **Дуулал 51:10**-д өгүүлдэг. Хэн ч өөрийн зүрхээ ариусгаж чадахгүй, яг Давид хаан шиг Бурханы өмнө очиж Бурханаас л зүрхийг нь ариусгахыг гуйх хэрэгтэй. Бурхан таны амьдралд шинэ зүйл хийхийг хүсэж байна. Тэр зөвхөн таньд туслахыг хүсэж байна, учир нь Тэр "Би чам дээр ариун усыг цацаж чиний бүх нүглийг цэвэрлэмээр байна" Би чамд шинэ зүрх, шинэ бодол өгье, Би чиний чулуун зүрхийг авч, дуулгавартай зүрх өгье. Мөн ариун сүнсээ өгч, чи миний тушаалыг дагаж хир зэрэг үгэнд орохыг харъя гэж амласаныг **Езекиель 36:25-27**-т өгүүлдэг. Энэ нь Бурхан, өөрийн хүү Есүс Христээр дамжуулан илгээсэн гэрээслэл юм. Энэ зурагт бид ариун сүнсийг дахин харж байна. Тэнгэр элч "Хэн эзэнд үнэнч, түүнийг би аюулаас хамгаална." **Дуулал 34:7;91:11; Даниел 6:22, Матай 2:13,13:39,18:10, Үйлс 5:19,12:7-10**

Copyright ANGP




5. БУРХАНЫ СҮМ

Чөтгөр ч гэсэн зурагт дүрслэгджээ. Тэр зүрхэнд ойрхон зогсож, хуучин гэртээ орох арга саам хайж байна. Ийм учраас бид "болгоомжтой бай, чиний дайсан, чөтгөр яг л арслан шиг хажууд чинь архирч хэн нэгнийг залгихаар зэхэж байна." **1 Петр 5:8** гэснийг санах ёстой. Тэр үргэлж Тэнгэр элчийн гэрлээр өөрийгөө халхалж, өөрийн заль мэхээр Бурханы сонгогдсон хүмүүс болон хүүхдүүдийг урвуулахыг оролддог. Хэрэв бид чөтгөрийг эсэргүүцвэл, тэр биднээс зугтан одох болно. **Иаков 4:7**

## ЗУРГАА ДАХЬ ЗУРАГ

Энэ бол урвагчийн тухай гунигт зураг юм. Нэг нүд нь анивчиж, царай нь зэвхийж, Христэд итгэсэн амьдрал нь нойрмоглож, нөгөө нүд нь ичгүүргүйгээр эргэн тойрноо сониучлан зуурдын дэлхийг хайрлаж эхэлж байна. Гэрэлт газар харанхуй нөмөрч, тэр Есүстэй хамт байж чадахгүй болжээ. Тэр доош унаж, эргэж босохооргүй болж байна. Тэр нүгэлд хүлэгдэж эсэргүүцэхийн оронд чөтгөрийн худал амлалт, нүглийг сонсож байна. Гэвч Тэр сүмд явдаг хэвээрээ, өөрийн дэлхийлэг нүгэлт хүслээ бусдаас нууж, Бурханыг хайрладаг хайр нь хөрсөөр. Тэр хоёр замын уулзвар дээр иржээ. Тэр дэлхийлэг зүйлстээ илүү татагдаж, Бурханыг хуурамчаар хайрлаж байна. Од түүний зүрхэнд үлдэж, харанхуйд уусна. Загалмайг жаргалтайгаар үүрэхээ больж, түүнд хэцүү санагдаж эхэлнэ. Түүний итгэл ганхаж, Бурхантай аминчлан залбирхаа больж, зүрхнийхээ гадна буй Чөтгөрийг оруулахад бэлэн байна. Тэр Бурханы үнэнч хүүхдүүдээс илүү нүгэлт хүмүүсийг таашаадаг болно. Тэр тогос мэт өөрөөрөө бахархаж эхэлнэ. Тэр Христээр аврагдсанаа мартана. Энэ нь нүгэлт нөхөд, чөтгөрийн зүйлстэйгээ учрах шалтаг болдог. Сүнслэг бус, хүсэл тачаал түүнийг доош унагана. Магадгүй Тэр бузар булайд татагдаж, журамгүй зүйлсийг дахин дахин харж, буруу зүйлсийг таашааж, Чөтгөрийн хорлолд автаж эхэлнэ. Үнэндээ бид түүний толгой дээр эргэлдэж буй Чөтгөрийн шувуудыг зайлуулж чадахгүй. Бид чөтгөрт чигчий хуруугаа өгөхөд л тэр бидний бугуйг атгана. Бидний сүнсийг мөнхийн тамд унагаана. Ийнхүү Бурхан бидэнд нүгэлт зүйлсээр оролдохгүй байхыг анхааруулсан. Аврагч, Есүс рүү ирэгтүн. Энэ зурган дээр түүний зүрхэнд сэлэм байна. Энэ нь Христэд үнэнч биш байгааг илтгэнэ. Хуваагдсан зүрх нийлэх ямар ч боломжгүй. Тэр Бурханаас илүү хүнээс айж, хүний боол болж, Бурханаас урвана. Зальт могойн хорлол, аюулаас сэрэмжлээгүй болгоомжгүй хүний зүрхэн дотор орж ирнэ. Бид Бурханы анхааруулгаас зөрж мөнгөнд дурлавал түүний хэлсэнээр "Залбирсаар бай тэгвэл дур тачаалд унахгүй" **Матай 26:41** Тиймээс өөрийгөө зогсож байна гэж боддог хүн унахгүйн тулд болгоомжтой байх хэрэгтэй **1 Коринт 10:12** Бид Бурханы өгсөн бүх хамгаалалтыг ашиглах хэрэгтэй, тэгвэл чөтгөрийн залинд автахгүй байж чадна аа.



Copyright ANGP




6.ХУВААГДСАН ЗҮРХ




7.УРВАСАН ЗҮРХ

# ДОЛОО ДАХЬ ЗУРАГ

Энэ зурагт өмнө нь Бурханы хайр, тэнгэрийн ивээлийг амссан Ариун сүнсийг өмнө нь мэдэрсэн нэгэн урвасан тухай өгүүлжээ. **Еврей 6:4** Тэрээр зурагт өөрийн амьдралаа Бурханд зориулаагүй үнэнийг харуулжээ. Үүнийг сайн мэдээ хэмээдэг. Бурхан өөртэй нь ярихад зөрүүдлэдэг хүн улам л доройтсоор байдаг. Есүс нэгэн удаа урвагчийн тухай ярихдаа "Хэрэв Чөтгөр хүний зүрхнээс гарч явбал шинэ амьдрах орчин хайдаг, хэрвээ олохгүй бол буцаж ирэх бөгөөд тэр цэвэр ариун болгоныг үзээд дахин өөр долоон чөтгөр дагуулан ирж зүрхийг эзэлнэ. Тэгээд энэ нь өмнөхөөсөө ч илүү долоо дордоно." **Лук 11:24-26** Тэдэнд юу тохиолдсоныг сургаалт үгст өгүүлсэн буй. "Нохой бөөлжсөнөө дахин долоодог" мөн "Цэвэрлэгдсэн гахай дахин шаварт хутгалддаг" **2 Петр 2:22** Библийн сударт урвагч, нүгэлтний талаар тодорхой дүрсэлсэн байдаг. Нүгэл нь заль мэх хэрэглэн хуучин байсан зүрхэндээ дахин орогнохыг хүсдэг. Түүний царайнаа зүрхэнд нь болж буй бүхэн тодорно. Ариун сүнс, тагтаа хоёр нь Сатантай хамт амьдарч чадахгүй учраас зүрхийг орхин одож байна. Сатантай хамт амьдарснаар Хүн хэзээ ч Бурханы сүм байх боломжгүй. Тэнгэр элч гунигтайгаар эргэн эргэн харж, хүү минь, охин минь буцаад ирэх болов уу" Тэр гахайны идэж байсан буурцгаар ходоодоо дүүргэхийг хүсэмжлэвч хэн ч юу ч түүнд өгсөнгүй, Тийнхүү тэрээр ухааран Эцгийн минь хөлсөлсөн хүмүүс идээ умдаанаар хичнээн элбэг дэлбэг байдаг билээ дээ. Гэтэл би энд харангадаж үхэх нь, босоод түргэхэн эцэг рүүгээ очъё" аавaa би тэнгэрийн эсрэг таны өмнө нүгэл үйлджээ, би цаашид таны хүү гэгдэх нүүргүй харин намайг зарцаа болгооч гэж хэлье. **Лук 15:16-20** Эцэг өөрийн гутарсан хүүг харж түүнийг уучлан элэгсгээр угтан авав. Энэ зурагт ямар ч гэмшил байхгүй, Бурхан луу хандсан зүйлгүй, Есүсээс уучлал гуйгаагүй зүрх дүрслэгджээ. Түүний оюун ухаан халуун төмөрт хайлж чимээгүй болжээ. Түүний нүд нээлттэй боловч хөл доор нь ангайж буй гүн тамыг эс үзнэ. Тэр одоо нүглээсээ ичихээ нэгэнт больж, гаднаа сайхан харагдавч "цагаанаар будсан булш адил гаднаа гоё харагдавч дотроо үхэгсдийн яс болоод бузар бүхнийг нуужээ" **Матай 23:27** Худал хуурмагийн эцэг Сатан ариун сүнсний орон зайг эзэлжээ. Бүх нүгэлт амьтад, чөтгөрүүд зүрхийг эзэгнэн байна.. Тэр хичнээн өөрийгөө чөтгөрөөс суллахыг хүсэвч тэд түүнийг хэрхэвч тавихгүй. "Мосегийн Хуулийг үл хэрэгсэгч хүн, хоёр буюу гурван гэрчийн гэрчлэлээр өршөөлгүй үхдэг. Бурханы хүүг уландаа гишгэж, өөрийг нь ариусгасан гэрээний цусыг бузар хэмээн үзээд нигүүлслийн сүнсийг доромжилсон хүн хэр зэрэг илүү хүнд шийтлэл эдэлбэл зохино гэж та нар бодож байна." **Еврей 10:28,29, 2 Петр 2:1-14**

Copyright AWGP




8.НҮГЭЛТНИЙ ТАВИЛАН

Хүндэт найз минь чи энэ зурагтай өөрийгөө адил гэж бодвол зүрхнийхээ гүнээс Бурханд хандан цөхрөлтгүй уйл. Тэр өөрт нь ирсэн хэнийг ч, хэзээ ч хүлээж авахад үргэлж бэлэн байдаг. **Еврей 7:25** Мөн бидний нүглийг өршөөхөд дандаа бэлэн байдаг. Тэр Чөтгөрийг номхтгон чиний зүрхнээс зайлуулж чадна. Харин чи үүнийг хийхийг чин сэтгэлээсээ хүсэх л хэрэгтэй. Та яг уяман өвчтэй хүнтэй адил түүн дээр оч. «Чи үнэхээр эдгэхийг хүсэж байна уу? Тэгвэл «эдгэр» хэмээн Есүс хэлсэн» **Марк 1:40-41** Харин чи үргэлжлүүлэн нүглээ үйлдэж харанхуйг гэрлээс илүүд үзвэл, ямар ч итгэл, ямар ч аврал байхгүй, учир нь чи амьдралыг биш үхлийг сонгож байна. »нүгэлийн төлөөс нь үхэл юм гэж » **Ром 6:23** бичсэнийг санаарай

## НАЙМ ДАХЬ ЗУРАГ

Бид энэ зурагнаас нүглээсээ болж бие нь өшөө хорслоор дүүрэн, сүнс нь үхлээс айх айдсаар дүүрсэн нэгэн Есүсийг дагахыг хүсэж буй тухай харж байна. Үхэл товлогдоогүй, хүсээгүй цагт ирэх болно. Худал хуурмагийн нүгэл аль хэдийнээ алга болж харин нүглийн гэсгээл хаяанд иржээ. Тэр хичнээн залбирсан ч аль эртнээс холбоогоо тасалсан Бурхантайгаа холбогдож чадахгүй. Ойр дотны хүмүүс нь айдаст автан орных нь хажууд зогсох бөгөөд тэдний уянгат үгс түүнд тусалж эс чадна. Түүний хөрөнгө баялаг ч сүнсийг нь аварч дийлэхгүй. Тэр Бурханд төвлөрч чадахгүй бөгөөд Чөтгөр түүнд тийм боломж олгоогүй ажээ. Бурхангүйгээр үхэж буй нэгнийг ганцхан хувь амьдралдаа хайрласан бүхэн нь ч, сүмийн Пастор ч аварч чадахгүй, аль эрт харьцаагаа тасалсан Бурханы шүүлтээс мултрахаас хэдийн өнгөрчээ. Тэр одоо «Амьд Бурханы гараас алдрах нь ямар аймшигтайг ойлгож эхлэнэ. **Еврей 10:31** Тэр өөрийг нь Бурхан үхлийн орон дээрээс аварна гэж итгэх боловч аль хэдүйнээ оройтжээ. Мянга мянган хүн Бурханы авралыг тосох боломжгүйгээр үхэж байна. Бурханыг дэргэдээ байхад түүнд хандах нь хамгийн чухал юм. «Бурханы үгийг сонсож амьдралдаа түүнийг хүндэлж байгсдаас Бурханы авралгүйгээр хэн ч үхэхгүй ээ.» Хараагдагсдаа, надаас зайл. Чөтгөр болоод түүний тэнгэр элч нарт нь бэлтгэсэн мөнхийн галд ор. **Матай 25:41** Бүгд нэг удаа үхэх бөгөөд, дараа нь Бурханы шүүлтэд ордог юм. **Еврей 9:27**

Copyright ANGP




9.ЯЛСАН ЗҮРХ

# ЕС ДЭХЬ ЗУРАГ

Энэ зурагт итгэл найдвараар дүүрэн нүгэл өшөө хорслоо давж гарсан Христэд итгэгчийг дүрсэлжээ. Түүнийг эцсийг нь хүртэл ятгасаар байсан боловч Есүс Христэд үнэнч хэвээр үлджээ. Есүстэй хамт явсан хэвээр. «Есүст хандсан хэвээр бай, эхнээсээ төгсгөл хүртэл Тэр бидэнд итгэж байсан шүү дээ.» **Еврей 12:1-2**

Сатан өөрийн бүх чөтгөрүүдтэй хамт итгэлт зүрхийг тойрох бөгөөд Бурханы хүүг буруу замд оруулахыг эрмэлзсээр байна. Бардамнал, үхэшгүй мөнх, мөнгөнд шунах гэх мэт зүйлс дүрслэгджээ. Энэ нь ирвэс илжгээр дүрслэгджээ. Нүгэл хилэнц ихэнхидээ өөрийн дүрээ нууж ирдэг гэсэн үг юм. Гэхдээ анхааралтай Христэд итгэгч түүнийг яаж ч дүрээ хувиргасан байлаа ч таньдаг. Нэг гартаа дарстай аяга барьсан нэгэн Христ итгэгчийг тойрон бүжих бөгөөд түүнийг нүгэлд уруу татахыг оролдох ажээ. Харин Есүст бүхнээ зориулсан нэгэн нүгэлээс алсын алсад байж Христтэй хамт үхэх болно. Хоёр дахь хүн Христд итгэгчийг хутгаар сийчэж байна. Үл итгэгчид Христэд итгэгчийг үргэлж шоолж доромжлон зүрхийг нь шархлуулж байдаг. Гэхдээ Христэд итгэгч нь хүмүүсийн хэлж байгааг бус Бурханы хэлж байгааг л сонсдог. Тэр Есүсийн үгийг л дагана. «Чамайг хүмүүс мөрдөж, доромжилж, чөтгөрийн худал хуурмагт дуудаж байвал баярлагтун учир нь чи миний дагалдагч юм. Баярлагтун, жаргалтай бай учир нь чи диваажинд очих болно.» **Матай 5:11,12** Нүгэлт, дэлхийлэг хүсэлт чөтгөр бидний Бурхантай холбогдсон холбоог таслахыг хүсдэг. Гэхдээ бид бат итгэлтэйгээр «Хэн нь ялладаг юм бэ? Христ үхээд, хожим нь амилуулагдсан, Бурханы баруун талд байдаг, биднийг зуучлагч нь юм» хэмээн итгэлтэйгээр хэлэх хэрэгтэй. **Ром 8:35** «Бурхан биднийг юугаар хайрласан түүгээрээ дамжуулан ялах болно.» **Ром 8:37**

«Бурханы хамгаалалтыг бүгдийг нь өөр дээрээ авагтун, тэр чамайг чөтгөрийн дайралтаас хамгаалах болно. Чөтгөрийн өдөр ирэхэд, тулалдааны төгсгөл хүртэл бид Есүст үнэнч байснаар нүгэлт зүйлсийг ялж хэзээ ч өнгө нь хувирахгүй гайхамшигт титэм авах болно. » **Ефес 6:10-18, 1 Петр 5:4** Од бол цэвэр ариун санааны билэгдэл юм. Түүний зүрх итгэлээр, ариун сүнсээр бялхжээ. Тэнгэр элч болох Бурханы үг түүнд сүүлчийн өдөр хүртэл ивээлийг өгөх болно. «Хэн ялсанд нь Бурханы цэцэрлэгт ургах амин модны жимснээс өгөгдөнө. Ялсан нь хоёр дахь үхэлдээ өвдөхгүй» «Ялсанд нь би нуугдмал эрч хүчийг өгнө. » Би тэдний шинэ нэрийг бичсэн цагаан чулууг бүгдэд нь хүртээнэ. «Ялсанд нь , эцсийг хүртэл хамт байсанд нь би эцгээсээ авсан эрх мэдлээсээ ч хүртээнэ.» Ялсанд нь цагаан хувцас өгч, би түүний нэрийг амийн номноос хэзээ ч арчихгүй. Миний эцэг болон түүний тэнгэр элчүүдийн тусламжтайгаар би, тэд надад харъяалагдахыг тунхаглах болно.» «би ялсаныг нь Бурханы сүмийн багана болгож, тэр үүнийгээ хэзээ ч болихгүй. » Ялсан нь миний баруун талд сэнтийний минь хажууд суух болно, ганцхан би л одоо ялсан бөгөөд эцгийнхээ хажууд одоо сууж байна. **Илчлэлт 2:7,11,17,26,3:5,12,21**

Copyright AVGF

Ам нь онгорхой мөнгөний уут нь Христэд Бурханд зөвхөн зүрхээ өгөөд зогсохгүй бүх мөнгөө өгсөнийг илтгэнэ. Мөнгөө дэмий үрэлгүй, ядууст туслаж, аравны нэгээ өгч, Бурханы төлөө хийж чадах бүхнээ хийснийг илтгэжээ. Зүсэм талх буюу загас нь түүнийг цэвэр ариун өөрийгөө удирдаж амьдарсныг харуулна. Тэр амьдралдаа хатуу ундаа ууж, бохир хоол идээгүй. **Үйлс 15:20** Тэр өөрийн биеэ хорлох зүйлд мөнгө зарсангүй, ямар ч төрлийн тамхи хэрэглэхгүй, хар тамхи татахгүй, мансуурулагч эм хэрэглэхгүй, харин эрүүл, цэвэр хүнс хэрэглэж байжээ. Түүний зүрх залбирлын гэр байв. Тэр цаг агаар ямар ч байсан, юу ч болж байсан сүмдээ очсон хэвээр байв. Тэр залбиралд дуртай болж, сүм, гэрийнхэн дундаа, өрөөндөө, хаа сайгүй залбирч Бурхантай холбогдохгүй бол Итгэгч болж чадахгүйгээ ухаарсан нэгэн юм. Дэлгэгдсэн ном нь Библи бөгөөд тэр өдөр бүр уншин судалж, хүчтэй итгэлийн амьдрал болоод мөнхийн гэрлийг олж авна. Энэ бол сүнсний өдөр тутмын хоол, цангахад нь ус, бохирдоход нь усны онгоц, өөрийгөө харах толь нь болдог. Тэр загалмайгаа авч явахдаа баяртай бөгөөд, түүнгүйгээр шан авахгүйгээ мэдэх болсон. Тэр Христтэй амьдрах шаардлагатай болсон, тэр өөрийн зүрхээ диваажинд зориулсан. Оюун ухаанаа дэлхийд бус Бурханд хандуулдаг. **Колоссай 3:1-2.** Тэр Бурхантай уулзахад бэлэн болж, горхины дэргэдэх мод адил, зөв цагтаа жимсээ ургуулна. **Дуулал 1:3** Жинхэнэ дарсны мөчир адил, арвин их жимс сагсайлгана. Тэр үхлээс айхыг үл мэдэх бөгөөд Бурханд хайрлагдаж ариун сүнсээр дамжин хайраар дүүрсэн зүрхтэй нэгэн юм.

## АРАВ ДАХЬ ЗУРАГ

Copyright ANCP

Есүс хэлэхдээ «Би бол амь, үнэн,зам мөн. Надад итгэсэн нь мөнх амьдарч, итгээгүй нь үхэх болно. Хэн надад итгэж, надтай амьдарна тэр хэзээ ч үхэхгүй » **Иохан 11:25,26**
Хэн миний үгийг сонсож надад итгэн тэр мөнхийн амиар шагнуулна. Тэр шүүгдэхгүй бөгөөд аль хэдүйнээ үхлээс аврагдсан. **Иохан 5:24** Итгэгч хүн үхлээс айх айдас, өшөө авалтыг үл мэдэрнэ. Үхэл сөнөж, тэр ялна. Есүсээр дамжуулан бидэнд өгсөн мөнх амийн төлөө Бурхан эзэндээ талархаарай. **1 Коринт 15:54-57** Бурхантай хамт алхдаг нэгэн үхлээс айдаггүй. Түүний үхэх цаг болоход тэр баярлана, элч Паулын хэлсэнээр «Би энэ амьдарлаас салж илүү сайхнаар Есүстэй амьдармаар байна.» **Филиппой 1:23** Итгэгч хүн өөрийх нь төлөө загалмай үүрч, нүглийх нь төлөөсөнд үхсэн Есүсийн царайг харуулж, Ариун сүнс түүнд Есүсийн хэлсэнийг сануулах болно. «Бүү санаа зов, надад бас Бурханд итгэ. Эцгийн минь гэрт хангалттай олон өрөө бий. Би эргэн ирж чамайг авна. Би хаана байна, чи мөн тэнд байх болно.» **Иохан 14:1-4** Бурхан өөрт нь хайртай нэгэнд өмнө нь харж, сонсож, төсөөлж ч байгаагүй зүйлсийг бэлдсэн. **1 Коринт 2:9** Тэнгэрт дэлхий дээрхитэй адил хэл байхгүй агаад сүр жавхлант диваажингийн хот нь мөнхийн улсад очигсдод зориулагдсан юм. Бурханы илгээсэн Тэнгэр элчийг сүүлийн зурагт дүрсэлжээ. Итгэгч өөрийг нь Бурхан луу аваачих




**10.ДИВААЖИНД ОЧИХ**

ариун сүнсийг хүлээж байна. Сүнс мөнх бус биеэс нь гарч өөрийнх нь төлөө загалмайд цовдлогдсон Есүс хаалгыг дэлгэнэ. «Сайн байна, итгэлт зарц минь. Ирээд миний жаргалаас хуваалцаач» **Матай 25:21** Сатан одоо түүнийг удирдахаасаа нэгэнт өнгөрсөн. Хөөрхий хүү үхжээ, түүнийг Тэнгэр элч нар  Абрахамын дэргэд хуриман дээр авчирна. **Лук 16:22** Дараа нь би тэнгэрээс гарч буй дууг сонслоо. Үүнийг тунхагла: Дөнгөж үхээд Бурханд үйлчлэх болсон нь жаргалтайяа гэхэд «Тиймээ үнэн» хэмээн сүнс хариулав. Тэр хэцүү ажлынхаа дараа амарч байгаадаа хэмжээлшгүй талархах агаад тэрээр Бурханд үнэнч байсныхаа мөнхийн шагналыг хүртэв. **Илчлэлт 14:13**

Copyright ANGP

# ТАЙЛАЛ ҮГ

Хүндэт уншигч минь, таньд хамгаас хайртай Бурхан шинэ зүрх өгөхийг юутай их хүснэ вэ. Бурхан таныг «Бүх зүрхээрээ над руу эргэж ир» **Дэд хууль 30:2** бичсэнээр урьж байна. Есүст гонсойсон, ядарсан, итгэл алдарсан, гомдож цөхөрсөн зүрхээ өгөгтүн, Бурхан зүрхийг чинь мөнх хайраараа дүүргэхийг хүсэж байна..
Өөрийн хуурамч зүрхний хүсэл тачаалд битгий хууртаарай, «Хүний зүрхнээс, чөтгөрийн, бузар булайд дуудсан зүйлс л гардаг.» **Марк 7:21** Нүгэл хилэнцээ хуучин хувцас шигээ тайлж чулуудчихаад , Есүсийн араас дагагтун. Нүглийн төлөөс нь үхэл юм. Харин Бурхан Есүсээр дамжуулан танд мөнхийн амийг үнэгүй өгч чадна. **Ром 6:23** Харин та Бурханд амьдралаа зориулж «Миний чамд хэлсэн сургаалд үнэнч бай, Есүс Христээр холбогдсон бидний итгэл, хайр бат бэх байх хэрэгтэй» хэмээн **2 Тимот 1:13** бичсэнийг дахин дахин санагтун. «Намайг хүчирхэг болгосон бидний эзэн Есүст би талархдаг. Яагаад гэвэл тэр намайг өөрийн итгэмжит зарцаар сонгож, өөрийнх нь нэрээр номлохыг зөвшөөрсөн гэж » Паулын **2 Тимот 1:12** хэлснийг сана.Бурханд итгэх итгэлээ бататга, ариун сүнсний хүчээр залбир, Бурханы хайраар бусдыг хайрла, зөвхөн Есүсийн араас өдөр бүр дага, зам, үнэн амь болсон Эцэг Бурхан чинь хүүхдүүд дээрээ удахгүй ирнэ. «Хаадын хаан, эздийн эзэн» **1 Тимот 6:15**

«Та нарыг бүдрэхээс хамгаалж, өөрийн мөнхийн оршихуйд баяр хөөртэйгээр, гэм зэмгүйгээр зогсоож чадах Есүс, бидний аврагч цорын ганц Бурхан, бидний мөнхийн эзэн Есүс Христийн алдар суу, сүр жавхлан, ноёрхол, эрх мэдэл нь бүх цагаас өмнө байсан шигээ эдүгээ болоод хойшид ч үеийн үед мөнхийн мөнхөд байх болтугай» Амен **Иуда 24:25**

Copyright ANGP

Copyright ANGP

Орчуулсан: **А.САНАА**

Зөвлөх: Robinson

Ишлэлүүдийг
«**Ариун бичээс Библийн Нийгэмлэг**»-ийн
зөвшөөрөлтэйгээр ашиглав

2010 он

## A SPECIAL WORD FROM ANGP
## UN MONDE SPÉCIAL DE L'ANGP
## UMA PALAVRA ESPECIAL DA ANGP

This booklet "The Heart of Man" is available in over 538 languages and dialects spoken throughout the world (Africa, Asia, The Far East, South America, Europe, etc.) Our Heart Book is now also available on cell phones, tablets, etc from www.angp-hb.co.za or as an APP "Heart of Man" on Android phones.

Le livre du "Coeur de l'homme" peut etre obtenu en plus de 538 langues et dialectes parles dans le monde entier, a savoir: Afrique, Amerique, Asie, Extreme Orient, Europe. Notre Livre du Coeur est maintenant aussi disponible sur votre Telephone cellular, plaques, etc. de www.angp-hb.co.za ou comme une Application "Heart of Man" sur telephones Android.

Este livro "O Coracao do Homem" e obtfdo em mais de 538 linguas e dialectos falados em todo o mundo, a saber: (Africa, Asia, America do Sul, Extremo Oriente, Europa, etc). O nosso Livro O Coração do Homem tambem esta agora disponivel em telefone celular, tablets, etc. de www.angp-hb.co.za ou como um aplicativo "Heart of Man" nos telephones celulares Android.

The 10 heart pictures contained in this booklet are also available in the form of large coloured picture charts (86 x 61cm) bound together in a set of 10 pictures. These "Heart Charts" can be obtained with European or African features and are particularly suitable to be used in conjunction with the Heart Book for class-teaching, open air evangelization etc. Kindly contact us to ascertain the latest subsidized price of this chart.

Les 10 images du coeur qui figurent dans ce livre peuvent etre obtenues en tableaux de couleur, format 86 x 61 cm, avec des physionomies europeennes ou africaines. Ils peuvent etre utilises en meme temps que le livre du coeur pour des classes bibliques, a

Copyright ANGP

l'ecole du dimanche ou lors de reunions de plein air. Soyez aimable de nous contacter pour assurer les derniers prix en cours du tableau.

As 10 imagens do coracao, contidas neste livro podem ser obtidas num conjunto de 10 imagens em colorido no tamanho de (86 x 61 cm). Estes "Cartazes do Coracao podem ser obtfdos com caracterfsticas Europeias e Africanas e podem ser usados em conjuncao com o mesmo livro em classes de ensino biblico, evangelizacao ou ao ar livre. Agradeciamos que nos contacta- se para confirmacao do ultimo preco dos cartazes.



Kindly write to us if you are able to assist us with further translations of our free Gospel literature, informing us of the language into which you could translate this Gospel literature. Your assistance would be appreciated.

If you have found salvation in Christ, or have been otherwise blessed through our Gospel literature, please let us know. We would like to thank God with you, and remember you further in our prayers.

Nous vous invitons a nous contacter pour faire des arrangements concernant de nouvelles traductions de notre litterature, nous informant de la langue dans laquelle vous pouvez traduire cette litterature evangelique. Votre aide sera beaucoup appreciee.

Si vous avez trouve le salut en Christ ou si vous avez ete beni par notre litterature, nous vous prions de nous le faire savoir. Nous aimerions remercier Dieu avec vous et prier pour vous.

Nos vos convidamos a nos contactar, afim de fazer qualquer arranjo concernente a novas traducoes de nossa literatura em outras Ifnguas. Vossa assistencia sera muito apreciavel.

Se tem encontrado a salvacao em Cristo, ou se tem sido abencoado por intermedio da nossa literatura evangelica, faca o favor de nos

Copyright ANGP

informar. Pois nos gostarfamos de agradecer a Deus juntamente convosco, e lembra-lo sempre em nossas oracoes.

For free Gospel literature, books and tracts in over 538 languages, write to:

Pour obtenir gratuitement de la litterature evangelique, des livres et des traites en plus de 538 langues, ecrivez a:

Para obter gratuftamente a literatura evangelica, livros e folhetos em mais de 538 Ifnguas diferentes escreva para:

**ALL NATIONS GOSPEL PUBLISHERS**
**P.O. Box 2191**
**PRETORIA**
**0001**
**R.S.A.**

info@angp.co.za

Copyright ANGP

A Gospel Literature Mission financed by donations
Une Mission de litterature evangelique financee de dons
Missao de literatura Evanqelica financiada por donativos

(Reg. No. 1961/001798/08)